

ТӨСӨЛ

**TRANS-ALTAI SUSTAINABILITY DIALOGUE 2023
GENDER EQUALITY AND SUSTAINABILITY**

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАРЫН НЭЭЛТИЙН ҮГ

Ladies and gentlemen, distinguished guests, and participants,

Good morning! It is my great pleasure and honor to welcome you all to Mongolia.

Хүндэт зочид төлөөлөгчид өө, эрхэмсэг хатагтай ноёд оо,

АЛТАЙ ДАМНАСАН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭРТ оролцож буй Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье!

Өнгөрсөн 2022 оны 10 дугаар сард Сөүл хотноо Стэнфордын Их Сургуулийн Ази Номхон Далайн Судалгааны Төв, НҮБ-ын 8 найм дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Муны байгуулсан Сайн Ирээдүйн төлөөх Бан Ки-мүн Сан “**НОМХОН ДАЛАЙ ДАМНАСАН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ**”-г анх удаа хамтран зохион байгуулсан. Уг чуулганыг зорилго нь НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хурдасгах, тогтвортой хөгжлийн 17 дугаар зорилт болох олон талт хамтын ажиллагааг дэмжих явдал байсан юм.

Энэхүү чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хангахад Ази, номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцол чухал үүрэгтэйг онцолж, жил бүр энэхүү яриа хэлэлцээг үргэлжүүлэхээр тогтсон юм.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтыг хурдасгах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилго бүхий энэхүү яриа хэлэлцээрийг энэ жил бид Улаанбаатар хотод “Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээр” нэрийн дор зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурал, АНУ-ын Стэнфордын Их сургууль, “Бан Ги Мүн” сан, БНСУ-ын Эйва Эмэгтэйчүүдийн Их сургуультай хамтран зохион байгуулж буй энэхүү чуулганаа бид Ази Номхон Далайн бүс нутгаас баруун зүгт улам тэлж Төв Азийн улс орнуудыг оролцуулан өргөжүүлж байгаа нь онцлог юм.

Төв Азийн зүрхэнд оршдог Алтайн нурууг тойрсон бүс нутаг нь сүрлэг уулс, уудам тал нутаг, онгон дагшин нууруудаас бүрддэг. Олон зуун жилийн турш Алтайн бүс нутаг нь өрнөд дорнодыг холбох уулзвар болж, хүн төрлөхтний түүх, өв соёл, хэл шинжлэлд өөрийн өвөрвөц байр суурийг эзэлдэг.

Өнөөдөр дэлхий дахин улс төр, эдийн засаг, нийгмийн олон бэрхшээл, сорилтуудтай тулгарч байна. Дэлхий дахиныг хамарсан цар тахал, түүнээс үүдсэн нийгэм, эдийн засгийн хүндрэл, улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн, геополитикийн техтоник шилжилтийн үед тогтвортой хөгжлийн төлөө Алтайн уулсыг дамнасан яриа хэлэлцээ хийж, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал юм. Энэхүү хамтын ажиллагаа, харилцан ойлголцлын суурь болох Алтай судлалыг эрчимжүүлэх асуудал нь бүс нутгийн тогтвортой байдал, хөгжлийн төлөөх хамтын эрмэлзлийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

ТӨСӨЛ

Энэ удаагийн Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ маань НҮБ-ын тогтвортой хөгжлийн 5 дугаар зорилт болох жендэрийн тэгш байдлыг хангах асуудал дээр төвлөрч байна.

НҮБ-аас зарласан Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн шударга ёс, эдийн засгийн хүртээмж гэх мэт олон харилцан уялдаатай өргөн хүрээний асуудлыг авч үздэг. Гэхдээ эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд манай дэлхийн, манай нийгмийн тэн хагасын оролцоог буюу жендэрийн эрх тэгш байдлыг хангахгүйгээр жинхэнэ үр дүнд хүрч чадахгүй.

Ийм ч учраас өнөөдрийн бидний чуулга уулзалтад эмэгтэйчүүдийн манлайлал, хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн эрх тэгш байдал, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл ба хүний эрхийн талаар Монгол Улсад болон бүс нутагт тулгамдаж буй асуудлаар, мөн Алтай судлалын олон улсын чиг хандлага гэсэн өргөн сэдвүүдээр ярилцах болно. Мөн эрдэмтэн судлаачид, бодлого тодорхойлогчид, иргэний нийгэм болон дараа үеийн манлайлагчид болох оюутан залуусын төлөөллийг оролцуулж, олон талт хамтын ажиллагааг ханган зохион байгуулж байна.

Чуулга уулзалт маань олон хүний хүчин чармайлт дор зохион байгуулагдаж байна. Энэ ташрамд Номхон далай дамнасан тогтвортой хөгжлийн яриа хэлэлцээрийг санаачилан манлайлж буй НҮБ-ын 8 дахь ерөнхийлөгч Бан Ги Мүн, Стэнфордын их сургууль, Эйва эмэгтэйчүүдийн их сургуулийн хамт олон, хүндэт зочиддоо гүн талархал илэрхийлье.

Мөн чуулга уулзалтыг дэмжин ажилласан Азийн хөгжлийн банк, Азийн сан, Европын сэргээн босголт хөгжлийн банк, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Оюу Толгой ХХК-д талархал илэрхийлье.

Бодит хамтын ажиллагааг эхлүүлсэн, бодлогын шийдэл гарц гаргалгааг дүгнэн ярьсан үр өгөөжтэй чуулга уулзалт болно гэдэгт итгэж байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.